



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар A/812

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн наймдугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 9 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалтын 2.15 дахь заалт "Үлээвэр хөгжим худалдан авах /Зэвсэгт хүчний 123 дугаар анги/" 15.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч /У.Болдбаатар/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 12 дугаар сарын 10-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 12 дугаар сарын 20-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлтэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 12 дугаар сарын 27-ны дотор тайлагнахыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч /У.Болдбаатар/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн

Зах А/812 Чх  
02 04012

бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Ц.Ганданповрон/, Цэргийн штабын дарга /Б.Ганхуяг/ нарт хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ